



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар *102*

Арвайхээр

Биеийн тамир, спорт хамтлаг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.4 дэх хэсэг, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 13 дугаар зүйлийн 13.2.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын биеийн тамир, спорт хамтлагийг дараах бүрэлдэхүүнээр байгуулсугай.

Спорт хамтлагийн ахлагч: Б.Дорждулам (Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч)

Гишүүд: Ц.Цэнд-Аюуш (Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга)
Ц.Энх-Амгалан (Хархорин сумын Татварын тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Бямбасүрэн (Хуулийн асуудал хариуцсан татварын улсын байцаагч)

С.Уранцэцэг (Татварын хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч)

2. Албан хаагчдын дунд биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан, алба хаагчдыг улс орны засаг захиргаа, албан байгууллагуудаас зохион байгуулагдаж буй спортын тэмцээн уралдааныг зохион байгуулж, бага хамт олныг чиглүүлэн ажиллахыг спорт хамтлагийн ахлагч (Б.Дорждулам)-д үүрэг болгосугай.

3. Биеийн тамир спортын арга хэмжээнд шаардагдах зардлыг тухай бүрт нь батлуулж холбогдох зардлаас гаргуулж байхыг нягтлан бодогч (С.Отгонлхагва)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн тасгийн дарга (А.Ганчимэг)-д даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/33 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ЭРДЭНЭСУВД

691001007